



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/44

Шивээговь сум

Хаврын нэгдсэн эргүүл шалгалт,
сурталчилгааны ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай” 01 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/94 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хаврын хуурайшилтын улирал эхэлж, хээрийн түймэр гарах эрсдэлийг өндөрсгөж байгаатай холбогдуулан болзошгүй хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Маналмаа

(2 дугаар багийн Засаг дарга)

А.Шинэбаяр

(Цагдаагийн хэсгийн дэслэгч,
зохицуулагч)

П.Дэлгэрбаяр

(Цагдаагийн хэсгийн дэслэгч, хэсгийн
мөрдөгч)

А.Тулга

(Шивээ Овоо хувьцаат компанийн
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн хэлтсийн ахлах инженер)

3. Эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Отгонбаяр)-т, малчид, иргэдэд чиглэсэн сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг (Ажлын хэсэг)-т, сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

114

Сумын Засаг даргын 2023 оны 04-р
сарын 06 ний өдрийн А/44
дугаар захирамжийн хавсралт

ХАВРЫН ЭРГҮҮЛ ШАЛГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ны, өдрийн А/94 дугаар захирамжийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, Гамшгаас хамгаалах, ойн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх болон хаврын хуурайшилтын үе эхэлж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд болзошгүй хээрийн түймэр, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, уул уурхайн тээврийг / маршрут, даац / хянах зорилгоор эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж ард иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг өгч, ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа

Эргүүл хяналт шалгалтын ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэх ба хуурайшилтын нөхцөл байдлаас хамаарч уг хугацааг өөрчилж болно.

Гурав. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Эргүүл шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Жич: Тухай бүр маршрут батлуулан эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулан тайлагнах.